



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/57/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он</p>	<p>Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас:70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 70484030 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.29 № 36
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан орон тоог мөрдөж ажиллагаагүй, татварын тодорхойлолтоор өглөг, авлага зөрүүтэй, зардлын зүйл анги зөрчиж гүйлгээ хийсэн, тендерт шалгараагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалт хийсэн, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй зэрэг материаллаг 34.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020205

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,549,791.74	44,356,599.02
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	0.54
31210	Төгрөг	0	0.54
33	АВЛАГА	1,820,688.74	1,003,520.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,820,688.74	0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	1,003,520.50
35	БАРАА МАТЕРИАЛ	45,729,103.00	43,353,077.98
35100	Түүхий эд материал	6,458,355.00	5,771,239.98
35130	Эм боох материал	6,458,355.00	5,771,239.98
35400	Хангамжийн материал	39,270,748.00	37,581,838.00
35410	Бичиг хэргийн материал	3,104,490.00	2,340,180.00
35420	Аж ахуйн материал	26,394,208.00	26,886,008.00
35450	Барилгын засварын материал	1,371,100.00	1,993,000.00
35460	Хүнсний материал	7,790,300.00	5,127,550.00
35470	Бусад хангамжийн материал	610,650.00	1,235,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	243,678,325.45	477,114,206.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	243,678,325.45	477,114,206.76
39200	Биет хөрөнгө	217,184,325.45	450,620,206.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	209,898,490.00	417,807,380.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,580,758.65	-29,845,365.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	24,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,000,000.00	0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	69,385,216.70	66,022,584.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56,731,078.56	-38,050,218.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,719,303.00	40,047,804.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,593,105.11	-29,403,406.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,471,300.00	2,471,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,385,041.93	-2,429,871.89
39300	Биет бус хөрөнгө	26,494,000.00	26,494,000.00
39301	Програм хангамж	2,859,927.85	2,859,927.85
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,249,927.85	-2,249,927.85
39303	Бусад биет бус хөрөнгө	25,884,000.00	25,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	291,228,117.19	521,470,805.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	54,958,550.08
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	54,958,550.08
41300	Өглөг	0	54,958,550.08
41360	Бусад өглөг	0	54,958,550.08
41361	Байгууллагад төлөх өглөг	0	45,935,550.08
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	9,023,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	291,228,117.19	466,512,255.70
51	Засгийн газрын хувь оролцоо	291,228,117.19	466,512,255.70
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	523,422,311.67	523,422,311.67
51200	Хуримтлагдсан үр дүн	-242,401,153.91	-67,117,015.40
51210	Өмнөх үеийн үр дүн	-235,923,271.46	-242,401,153.91
51220	Тайлант үеийн үр дүн	-6,477,882.45	175,284,138.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,206,959.43	10,206,959.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	291,228,117.19	521,470,805.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	430,956,240.00	721,519,978.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,857,840.00	272,231,512.38
120	Нийтлэг татварын бус орлого	12,857,840.00	272,231,512.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,636,600.00	14,708,158.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,636,600.00	14,708,158.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	251,579,064.88
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	221,240.00	5,944,289.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,098,400.00	449,288,466.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	201,304,000.00	0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,304,000.00	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.00	28,980,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	28,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	980,000.00
1330	Төсвийн захирагчдаас	0	40,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	0	20,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0	20,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	216,694,400.00	380,308,466.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	216,694,400.00	380,308,466.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	437,434,122.45	546,235,839.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,434,122.45	546,235,839.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,243,647.76	517,925,839.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,227,268.55	281,092,608.50
210101	Үндсэн цалин	150,429,006.51	162,880,413.00
210102	Нэмэгдэл	63,307,562.38	90,214,067.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,955,000.00	10,493,116.40
210104	Урамшуулал	23,535,699.66	17,505,011.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,877,347.38	37,044,210.65
210201	Тэтгэврийн даатгал	22,305,013.52	28,305,240.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,625,246.77	2,357,886.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,039,720.85	1,375,512.27
210204	Ажилгүйдлийн даатгал	409,518.91	291,322.91
210205	Эрүүл мэндийн даатгал	4,497,847.33	4,714,248.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,009,779.52	58,448,447.79
210301	Гэрэл, цахилгаан	5,073,250.17	4,707,671.79
210302	Түлш, халаалт	43,639,517.00	49,348,522.08
210303	Цэвэр, бохир ус	5,297,012.35	4,392,253.92
210304	Байрны түрээс	0	0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,754,450.00	30,624,529.40
210401	Бичиг хэрэг	3,327,780.00	2,631,560.00
210402	Тээвэр, шатахуун	2,016,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,097,620.00	1,304,268.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	356,000.00	483,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,681,950.00	23,349,701.38
210408	Бараа материал акалсны зардал	3,275,100.00	2,355,500.00
2105	Нормативт зардал	44,993,730.00	55,671,339.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,048,830.00	32,210,439.14
210502	Хоол, хүнс	21,944,900.00	23,460,900.00

Говь-Алтай аймгийн Уламжлалт ачаагаа үйлдвэрлэсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,147,905.85	3,513,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	700,000.00	0
210604	Урсгал засвар	17,447,905.85	3,513,400.00
2107	Томилолт, зочны зардал	386,900.00	0
210702	Дотоод албан томилолт	386,900.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	879,050.00	193,970.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,500.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,980.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	52,120.00	52,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	318,300.00	0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	41,800.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,967,216.46	51,337,334.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	25,098,150.82
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоротдол	16,967,216.46	26,239,183.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,190,474.69	28,310,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	28,310,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	28,310,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,690,474.69	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,690,474.69	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-6,477,882.45	175,284,138.51
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,477,882.45	175,284,138.51

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	-235,923,271.46	297,705,999.64
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	-235,923,271.46	297,705,999.64
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-6,477,882.45	-6,477,882.45
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	-242,401,153.91	291,228,117.19
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	-242,401,153.91	291,228,117.19
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	-242,401,153.91	291,228,117.19
19	Тайлант үеийн үр дүн	0	0	175,284,138.51	175,284,138.51
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	-67,117,015.40	466,512,255.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	430,735,000.00	462,993,103.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,636,600.00	14,708,158.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,636,600.00	14,708,158.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,636,600.00	14,708,158.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,636,600.00	14,708,158.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,098,400.00	448,284,945.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	201,304,000.00	0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,304,000.00	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.00	28,980,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	28,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	980,000.00

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1330	Төсвийн захирагчдаас	0	40,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	0	20,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0	20,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	216,694,400.00	379,304,945.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	216,694,400.00	379,304,945.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	426,135,000.00	454,897,102.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,135,000.00	454,897,102.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,944,525.31	426,587,102.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,411,722.56	281,092,608.50
210101	Үндсэн цалин	152,613,460.52	162,880,413.00
210102	Нэмэгдэл	63,307,562.38	90,214,067.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,955,000.00	10,493,116.40
210104	Урамшуулал	23,535,699.66	17,505,011.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,877,347.38	37,283,184.65
210201	Тэтгэврийн даатгал	22,305,013.52	28,544,215.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,625,246.77	2,357,885.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,039,720.85	1,375,512.27
210204	Ажилгүйдлийн даатгал	409,518.91	291,322.91
210205	Эрүүл мэндийн даатгал	4,497,847.33	4,714,248.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,009,779.52	30,682,949.71
210301	Гэрэл, цахилгаан	5,073,250.17	4,707,671.79
210302	Түлш, халаалт	43,639,517.00	21,583,024.00
210303	Цэвэр, бохир ус	5,297,012.35	4,392,253.92
2104	Хангамж, бараа материалын зардал	11,852,170.00	18,486,786.02
210401	Бичиг хэрэг	4,450,770.00	1,327,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,526,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,092,000.00	1,669,468.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	356,000.00	483,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,427,400.00	14,506,218.00
2105	Нормативт зардал	49,225,850.00	42,466,291.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,665,850.00	28,633,691.00
210502	Хоол, хүнс	22,084,000.00	13,394,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,476,000.00	438,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,943,505.85	8,146,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,499,000.00	6,136,800.00
210604	Урсгал засвар	17,444,505.85	2,009,500.00
2107	Томилолт, зочны зардал	386,900.00	0
210702	Дотоод албан томилолт	386,900.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,237,250.00	989,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,500.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,980.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	703,000.00
210807	Газрын төлбөр	52,120.00	52,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	318,300.00	0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,000.00	92,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	7,439,363.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	7,439,363.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,190,474.69	28,310,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	28,310,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	28,310,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,690,474.69	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,690,474.69	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,600,000.00	8,096,000.54
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,600,000.00	8,096,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,600,000.00	8,096,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,600,000.00	8,096,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,600,000.00	8,096,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,600,000.00	-8,096,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,980,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,980,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,000.00
2105	Нормативт зардал	670,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	670,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,310,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,980,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	980,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, татварын байгууллагатай тооцоо нийлж санхүүгийн тайланг бодитой үнэн зөв хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь Монгол уламжлалт анагаах ухаан /дорно/-ыг европын анагаах ухаан /өрнө/-тэй хослуулж бүс нутгийн хүн амд уламжлалт эмчилгээний 2 дугаар шатны нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх төрийн өмчит байгууллага байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт өөрчлөлт орсон байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоол, Эмнэлгийн тусламжийн хуулийн дагуу тус байгууллагыг гүйцэтгэлээр санхүүжүүлж байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж байхгүй. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 439.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 546.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.9 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79.0 хувиар буюу 230.2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны эхний үлдэгдэлгүй, тайлант оны эцэст 1.0 сая төгрөгийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагын үлдэгдэлтэй тайлагнасан нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт дутуу орсонтой холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 43.4 сая төгрөг болж 2.4 сая төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл буурсантай холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 79.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 5.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 85.6 сая төгрөгийн материалыг зарцуулан оны эцэст 43.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 579.1 сая төгрөг болж 185.9 сая төгрөгөөр өссөн. Төсвийн хөрөнгөөр 8.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн, 244.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 24.9 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж ашиглагдах жил, үнийг шинэчлэн 7.5 сая төгрөгөөр орлого авчээ. Аймгийн ИТХ-ын шийдвэрээр 48.9 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 579.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 466.5 сая төгрөг болж 175.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл (67.1) сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 466.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 32.9 сая төгрөгөөр бууруулж 434.0 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоол, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу тус байгууллагыг гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаа тул төсвийн гүйцэтгэлийн тайлан баталгаажуулаагүй болно.

Үндсэн дансанд гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 379.3 сая төгрөгийн санхүүжилт авч, төсвийн ерөнхийлөн захирагчаас 20.0 сая төгрөг, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд 20.0 сая төгрөгийн нийт 419.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод 1.0 сая төгрөг, Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 28.0 сая төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримт, татварын тодорхойлолт хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 23 мэдээллийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагаатай холбоотой 26.0 сая төгрөгийн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 104.8 сая төгрөгийн орлого, 133.8 сая төгрөгийн зарлага, 5.0 сая төгрөгийн худалдан авалт, 54.9 сая төгрөгийн өглөг, 1.0 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 И-баримттай холбоотой

Тус байгууллага нь тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авалт хийхдээ И-баримтгүй 47.2 сая төгрөгийн гүйлгээ хийснээс аудитын явцад 45.2 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 37.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бүтэц орон тоо, татварын тодорхойлолт, өглөг, авлагын бүртгэл, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 181.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 144.9 сая төгрөгийн алдааг залруулж, 36.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 99.6 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалтын 45.3 сая төгрөгийн и баримтыг нөхөн шивүүллээ.

4.2 Төлбөрийн акт

төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 19.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батлагдсан орон тоог мөрдөлгүй 1 орон тоо илүү ажиллуулж 3.1 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" Эрүүл мэндийн газрын 2015 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн Б/21 тоот тушаалтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зардлын зүйл анги зөрчин бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 7.1 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах"; гэж заасныг зөрчиж, үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тендерт шалгараагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 4.3 сая төгрөгийн хүнсний материал худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 23 мэдээллийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагаатай холбоотой 26.0 сая төгрөгийн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 104.8 сая төгрөгийн орлого, 133.8 сая төгрөгийн зарлага, 5.0 сая төгрөгийн худалдан авалт, 54.9 сая төгрөгийн өглөг, 1.0 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аж ахуйн нэгж, байгууллагаас 2.0 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг

баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"; гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	8	181.4	1	144.9	0	0	6	36.4	1	